

ТӨСӨЛ (2021 оны 9-р сарын 21)

Цагаач Хүн Амтайгаа Итгэлцэх Итгэлийг Бэхжүүлэх Арлингтоны Амлалт Баримт Бичиг

Товч агуулга

Арлингтон хүчтэй байгаагийн гол шалтгаан оршин суугчдын угсаа гарал, арьс өнгө болон харилцах хэлний олон талт байдал хэмээн манай тойргийнхнийхон үздэг. Иргэн бүрийг чухалчлан үздэг, хүн бүр хөгжин боловсрох боломж бүхий найрсаг, хүртээмжтэй орчин нөхцөл бүрдүүлэх нь бидний зорилго юм. Иргэншлийн байдал, цагаач статустай эсэхээс үл хамааран бүх оршин суугчийнхаа эрхийг хамгаалж, эдийн засгийн амьдралд оролцох боломжийг хүн бүрт олгохын төлөө Арлингтон тойрог ажилладаг.

Цагаач иргэд хувийн мэдээллийг нь цагаачлалын албанд дамжуулахаас эмээхгүйгээр Арлингтон тойргоос хэрэгжүүлж буй халамжийн болон бусад үйлчилгээнд хамрагдах баталгааг хангах замаар иргэдийн итгэлийг бэхжүүлж, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, халамжийн үйлчилгээг сайжруулах тойргийн бодлогоо дахин баталгаажуулах нь чухал ач холбогдолтой хэмээн бид үзэж байна.

Холбооны цагаачлалын хуулийг хэрэгжүүлэх үүргийг холбооны засгийн газрын үүрэг учраас уг хуулийг хэрэгжүүлэхэд Арлингтоны хөрөнгө санхүүг зарцуулах нь төдийлөн зохимжтой зүйл биш юм. Гааль Цагаачлалын Алба (ICE)-тай хамтран ажиллахыг шаардсан холбооны болон муж улсын бүх дүрэм журам болон шүүхийн шийдвэр, зарлан дуудах зэргийг Арлингтон тойргийнхон хэрэгжүүлэхээс бусдаар цагаачлалын бусад үйл ажиллагаанд ашиглуулах зорилгоор хувь хүний мэдээллийг бусдад өгөхгүй болно.

Бодлогын баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг

Төрийн үйлчилгээний хүртээмж

Бүх оршин суугчдаа төрийн үйлчилгээг тэгш хүртээх үүргээ Арлингтон тойрог чин үнэнчээр биелүүлнэ.

- Эрүүл мэнд, хүнс, хоргодох байр болон боловсролын үйлчилгээ үзүүлэхдээ Арлингтон тойргийн захиргаанаас тухайн оршин суугчийн хуулийн статусыг асуудаггүй бөгөөд цаашид ч асуухгүй болно.
- Орон нутгийн цагдаа, гал, яаралтай түргэн тусламж, цэцэрлэгт хүрээлэн болон амралтын газрууд, номын сан, Арлингтоны ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ, санхүүгийн яаралтай тусламж, эрүүл мэнд болон мансууруулах бодис хэрэглэгсдэд үзүүлэх зэрэг бараг бүх төрийн үйлчилгээнд хамрагдахад тухайн иргэнээс хууль ёсоор амьдарч буйгаа батлахыг Арлингтон мужаас шаарддаггүй билээ. Гэвч холбооны засгийн газраас санхүүждэг зарим хөтөлбөр үйлчилгээнд хамрагдахын тулд та шаардлага хангаж буйгаа батлахын тулд хууль ёсны бичиг баримт үзүүлэх хэрэгтэй болохыг анхаарна уу.

Хуулийн хэрэгжилт

Холбооны цагаачлалын хуулийг хэрэгжүүлэх мөн иргэний цагаачлалын журмыг хэрэгжүүлэх нь холбооны засгийн газрын үүрэг бөгөөд үүнд Арлингтоны хөрөнгө санхүүг зарцуулах нь төдийлөн зохимжтой зүйл биш гэдэгт Арлингтон тойргийн засаг захиргааныхан итгэдэг.

- Цагдаад мэдүүлэг өгөх, иргэдэд чиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох, цагдаагийн үйлчилгээний үр ашгийг хүртэх зэрэг хүний эрх нь иргэншлэлийн байдал болон цагаачлалын асуудалтай холбоогүй юм.
- Цагаачлалын статусыг тодорхойлох болон судлах цорын ганц зорилгоор иргэнийг хянах, хорих болон байцаах байр суурийг Арлингтон тойргийн засаг захиргаа баримтлахгүй.
- Холбооны Цагаачлалын Хуулийн биелэлтийг хангуулах үүргийг Арлингтон тойрог хүлээхгүй.

Мэдээллийн хүртээмж

Бид хувь хүний мэдээлэл нууцлалыг чандлан хадгалахаа амлаж байна.

Засаг Захиргаанд Итгэх Итгэлийн Баримт Бичгийн бүрэлдэхүүнд мэдээллийн хүртээмжтэй холбоо бүхий дараах зүйлс орсон байна. Үүнд:

- Хувийн нууцыг чандлах
- Мэдээлэл хүсэх, хүртэх, өгөх
- Төрийн байгууллага, үйлчилгээ, нөөц хөрөнгөд хүртээмжтэй байх
- Иргэний Цагаачлалын хуулийг хэрэгжүүлэхэд тойргийн төсвийг ашиглах
- Иргэншил, цагаачлалын статусаас үл хамааран иргэдийг дэмжих
- Иргэний цагаачлалын хуулийн хэрэгжилтийг чиглүүлэх
- Холбооны бүртгэлд оролцох
- Харилцаа холбоо болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаа